

ХААИС-ИЙН БАКАЛАВРЫН СУРГАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл	2
Хоёр. Нэр томъёо	2
Гурав. Элсэлтийн үйл ажиллагаа.....	3
3.1. Элсэлтийн зохион байгуулалт	3
3.2. Элсэгчдэд тавигдах шаардлага.....	4
3.3. Хөнгөлөлттэй нөхцлөөр элсүүлэх	4
Дөрөв. Сургалтын үйл явц, агуулга.....	5
4.1. Ерөнхий зүйл.....	5
4.2. Өдрийн сургалт.....	6
4.3. Эчнээ сургалт.....	7
4.4. Зайн сургалт	7
4.5. Хавсарга, хос хөтөлбөрийн сургалт	8
4.6. Хос дипломын сургалт	8
Тав. Шилжилт, хөдөлгөөн.....	9
5.1. Оюутанд чөлөө олгох	9
5.2. ХААИС-д шилжин суралцах.....	9
5.3. ХААИС-аас шилжүүлэх	10
5.4. Оюутныг сургуулиас чөлөөлөх	10
Зургаа. Оюутны мэдлэг, чадвар, хандлагыг дүгнэх.....	11
6.1. Стандарт үнэлгээ.....	11
6.2. Стандарт бус үнэлгээ	12
6.3. Хичээлийн үнэлгээг шууд тооцох	13
Долоо. Оюутныг урамшуулах	13
7.1. ХААИС-ийн Захирлын нэрэмжит батламж	13
7.2. ХААИС-ийн Захирлын нэрэмжит тэтгэлэг	14
7.3. Бүрэлдэхүүн сургуулийн шилдэг оюутан	14
Найм. Эрдэм шинжилгээний ажил	15
8.1. Эрдэм шинжилгээний ажлын зохион байгуулалт.....	15
8.2. Бакалаврын оюутны эрдэм шинжилгээний ажлыг дүгнэж урамшуулах	16
Ес. Төгсөлтийн үйл ажиллагаа	17
Арав. Журмын хэрэгжилтийн хяналт, үнэлгээ	18
Хавсралтууд.....	18

ХААИС-ИЙН БАКАЛАВРЫН СУРГАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол Улсын Боловсролын тухай болон Дээд боловсролын тухай хууль, тэдгээрт нийцүүлэн Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан холбогдох дүрэм, журам, ХААИС-ийн дүрмийг үндэс болгон ХААИС-д дээд боловсролын диплом, бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад энэхүү журмыг баримтална.
- 1.2. ХААИС-ийн бакалаврын сургалтын журмын (цаашид “журам” гэх) зорилго нь элсэгч, суралцагч, төгсөгчдөд тавигдах нийтлэг шаардлага, сургалтын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, хэрэгжилтийг хангахад чиглэгдэнэ.
- 1.3. Бакалаврын сургалтын зорилго нь бүрэн дунд боловсролтой иргэнд шинжлэх ухааны суурь мэдлэг эзэмшүүлж, цаашид өөрийгөө хөгжүүлэх онол, арга зүйн мэдлэг, чадварыг төлөвшүүлэх замаар хөдөө аж ахуйн салбарт ажиллах мэргэжилтэн бэлтгэхэд оршино.

Хоёр. Нэр томъёо

Тус журамд хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

- 2.1. “Сургалтын хөтөлбөр” гэж суралцагчдын сонирхол, хувь хүний болон нийгмийн хэрэгцээ, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хандлагад нийцүүлэн тэдэнд хөдөөгийн хөгжил, экологи, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн техник, технологи, нийгэм эдийн засгийн чиглэлээр мэргэжлийн мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэх, өөрийгөө хөгжүүлэх арга барил төлөвшүүлэхэд чиглэгдэх баримт бичгийг;
- 2.2. “Хавсарга хөтөлбөр” гэж оюутанд суралцаж буй үндсэн мэргэжлийнх нь зэрэгцээ өөр мэргэжлийн чиглэлээр системтэй мэдлэг, чадвар эзэмшүүлэх зорилготой эзэмшсэн бакалаврын зэргийн дипломонд нэмэлт хавсралт олгох хөтөлбөрийг;
- 2.3. “Хос хөтөлбөр” гэж оюутанд суралцаж байгаа үндсэн мэргэжлээс өөр хоёр дахь мэргэжил эзэмшүүлэх зорилготой бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийг;
- 2.4. “Хос дипломын сургалт” гэж нэг хөтөлбөрөөр хоёрдогч улсад суралцуулж хоёр улсын бакалаврын зэрэг олгох сургалтыг;
- 2.5. “Сургалтын төлөвлөгөө” гэж сургалтын ерөнхий зохион байгуулалт, агуулгын багтаамж, норматив хугацаа, судлах хичээлийн цэс, хэлбэр, тэдгээрийн багтаамж, дараалал, залгамж холбоо, сургалт үйлдвэрлэлийн дадлагын төрөл, хугацаа, төгсөлтийн ажлыг тусгасан бакалаврын сургалтын үндсэн баримт бичгийг;
- 2.6. “Санал болгох сургалтын төлөвлөгөө” гэж сургалтын төлөвлөгөөн дэх заавал болон сонгон судлах хичээлийн уялдаанд үндэслэн оюутныг хичээл сонгоход нь чиглүүлэх үндсэн баримт бичгийг;

- 2.7. “Хичээлийн стандарт хөтөлбөр” гэж тухайн хичээлээр суралцагчдын эзэмшвэл зохих онол, практикийн мэдлэг, чадвар, дадал, хандлагын агуулга, үнэлгээ, цагийн багтаамж, ашиглавал зохих ном, сурах бичгийн жагсаалтыг багтаасан сургалтын үндсэн баримт бичгийг;
- 2.8. “Хичээлийн кодчилал” гэж сургалтын төлөвлөгөөн дэх хичээлүүдийн залгамж холбоо, агуулгын гүнзгийрэлт, сонголтын мэдээллийг харуулах зорилгоор ашиглагдах үсэг (тухайн хичээлийн англи нэрийн товчлол) ба тоо (тухайн хичээлийн агуулгын гүнзгийрэлт)-гоор илэрхийлэгдэх индексийг;
- 2.9. “Багц цаг” гэж боловсролын агуулгын багтаамжийг жиших нэгж бөгөөд оюутны эзэмшсэн мэдлэг чадвар, багшийн сургалтын ажлын хэмжээ, сургалтын төлбөрийг тооцох үндсэн хэмжүүр, дээд боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилт, зохион байгуулалтын харилцааг зохицуулах хэрэгслийг;
- 2.10. “Улирал” гэж хичээлийн нэг үеийн үргэлжлэх хугацаа буюу найм (үндсэн), дөрвөн (нэмэлт) долоо хоногийн хугацааг;
- 2.11. “Сургалтын гарын авлага” гэж сургалтын төлөвлөгөө, хичээлүүдийн хөтөлбөр, стандарт, бие даан судлах хичээлийн агуулга, ашиглах үндсэн болон нэмэлт сурах бичиг, сургалттай холбогдолтой дүрэм, журам, хичээлийн жилийн сургалтын нэгдсэн хуваарийг тусгасан албан ёсны баримт бичгийг;

Гурав. Элсэлтийн үйл ажиллагаа

3.1. Элсэлтийн зохион байгуулалт

- 3.1.1. Элсэлтийг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан дүрэм, журамд нийцүүлэн, Монголын их, дээд сургуулиудын консорциумтай хамтран зохион байгуулна.
- 3.1.2. Төрийн захиргааны байгууллагын захиалга, зах зээлийн эрэлт, хэрэгцээ, сургуулийн материаллаг бааз, багшлах бүрэлдэхүүний хангамж зэргийг харгалзан сургуулийн удирдах зөвлөлөөр батлуулсан хяналтын тооны дагуу оюутан элсүүлнэ.
- 3.1.3. ХААИС-ийн Захирлын тушаалаар батлагдсан элсэлтийн комисс элсэлтийг Улаанбаатар хот болон орон нутагт зохион байгуулна.
- 3.1.4. Элсэгчдийн өгвөл зохих шалгалтын төрөл, босго оноо, суралцах мэргэжлийн чиглэл, хэлбэрээс хамаарч ялгаатай байх бөгөөд үүнийг жил бүрийн элсэлтийн журамд тусгаж 2 дугаар сарын 1-ний дотор олон нийтийн мэдээллийн хэрэгслээр болон www.muls.edu.mn, www.elselt.muls.edu.mn цахим хуудсаар дамжуулж олон нийтэд түгээнэ.

3.2. Элсэгчдэд тавигдах шаардлага

3.2.1. Элсэгч нь тухайн мэргэжлийн чиглэлд харгалзах ерөнхий шалгалтын аль нэгийг өгсөн байна. Ландшафтны архитектур мэргэжлээр элсэхийг хүсэгчид ерөнхий шалгалтаас гадна хар зургийн ур чадварын шалгалт өгсөн байна.

3.2.2. ХААИС-ийн дэргэдэх лицей, гүнзгийрүүлсэн сургалттай ангиудаас сурлагын дүнгийн жагсаалтаар эхний 15 байранд шалгарсан, ерөнхий шалгалтын оноо 600-аас дээш оноо авсан сурагчид өөрийн хүссэн мэргэжлийн ангид элсэх боломжтой.

3.2.3. Элсэгчид “ХААИС-ийн сургалтын нэгдсэн хуанли”-д заасан хугацаанд буюу 08-р сарын сүүлийн, хичээлийн жилийн эхний “0” долоо хоногт багтаан бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанд бүртгүүлнэ. Элсэгч бүртгүүлэхээр ирэхдээ дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

- 1.Ерөнхий шалгалт өгсөн батламж;
- 2.Боловсролын үнэмлэх, гэрчилгээ, диплом;
- 3.Суралцагчийн хувийн хэрэг;
- 4.Иргэний үнэмлэхний баталгаажуулсан хуулбар;
- 5.Тухайн жилийн 3*4 хэмжээтэй 2 хувь цээж зураг;
- 6.Тухайн хичээлийн жилийн эхний улирлын сургалтын төлбөр болон бусад шаардлагатай хураамжийг төлсөн баримт;
- 7.Хөнгөлөлттэй нөхцөлөөр элсэх болзлыг хангасан оюутнуудын хувьд зохих баримт бичгийн баталгаажуулсан хуулбар;
- 8.Төрийн сангийн зээл тусламжид хамрагдах бол холбогдох бичиг баримтуудын баталгаажуулсан хуулбар;

3.2.4. Оюутан элсүүлэх тухай Захирлын тушаал батлагдаж, “Бакалаврын сургалтын гэрээ”¹ байгуулан, оюутны код, сургалтын удирдлагын мэдээллийн систем (ULMS)-ийг ашиглах эрх олгогдсоноор тухайн элсэгчийг ХААИС-д бүрэн элссэнд тооцно.

3.2.5. Дурьдсан хугацаанд сургалтын албанд бүртгүүлээгүй, ерөнхий шалгалтын болон боловсролын баримт бичгийн зөрчилтэй оюутныг элсэгчдийн бүртгэлээс хасна.

3.2.6. Эчнээ ангид элсэхийг хүсэгчид бакалаврын зэргийн дипломтой бол 2.5 жил, бусад суралцагч 4.5 жилийн хөтөлбөрөөр элсэн суралцаж болно.

3.2.7. Дээд боловсролтой иргэн хоёр дахь дээд боловсрол эзэмших хүсэлтэй бол өмнө нь төгссөн сургуулийн дээд боловсролын дипломыг үндэслэн элсүүлнэ.

3.3. Хөнгөлөлттэй нөхцөлөөр элсүүлэх

Олон улс, улсын албан ёсны олимпиадад эхний 1-10 дугаар байр, бүс, аймгийн хэмжээний олимпиад, уралдаанд эхний 1-5 дугаар байранд шалгарагсдыг олимпиадад оролцсон чиглэлийн дагуу шууд элсүүлэн суралцуулна.3.3.2. Урлаг, спортын гоц

¹ Бакалаврын сургалтын гэрээний загварыг Хавсралт 1-т харуулав.

авьяастай, олон улс, улсын хэмжээний уралдаан, тэмцээнд эхний 3 байрт шалгарагсдыг ерөнхий шалгалтын чиглэл, босго оноог харгалзан сонирхсон мэргэжлээр шууд элсүүлэн суралцуулж болно.

3.3.3. Хөдөө орон нутагт дахь салбарын мэргэжилтний хангамж, шаардлагыг үндэслэн хөнгөлөлттэй нөхцөлөөр оюутан элсүүлж болно. Үүнийг орон нутгийн засаг, захиргааны тодорхойлолт, дэмжлэгийг үндэслэн хамтран зохион байгуулна.

Дөрөв. Сургалтын агуулга, үйл явц

4.1. Ерөнхий зүйл

4.1.1. Бакалаврын сургалтыг өдөр, орой, эчнээ, зайн сургалтын хэлбэрээр зохион байгуулж болно.

4.1.2. Сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулахдаа “Сургалтын гарын авлага”-ыг ашиглах бөгөөд тус гарын авлага нь өмнөх хичээлийн жилийн 5-р улиралд багтаж онлайнаар нийтлэгдэж, хэвлэмэл байдлаар номын сан, тэнхимүүдэд тараагдсан байна. Сургалтын гарын авлагад дараах зүйлсийг багтаана. Үүнд:

1. Хөтөлбөрүүдийн танилцуулга, төлөвлөгөө:

- Заавал үзэх хичээлүүд;
- Чөлөөт сонголтын чиглэлүүд;

2. Хичээлүүдийн танилцуулга, төлөвлөгөө:

- Хичээлийн ерөнхий агуулга;
- Хичээлийн багц цаг;
- Хичээлээр эзэмшүүлэх ур чадвар;
- Улирлын шалгалт авах арга;
- Хичээл заах багш болон холбогдох зохицуулагч (тэнхимийн туслах);
- Хичээлийг заах болон сургах арга барил;
- Хичээлийн өмнөх холбоо;
- Тухайн хичээлийг сонгох боломжтой оюутны тоо;

3. Хичээлийн жилийн календарчилсан төлөвлөгөө:

- Хичээлийн жилийн ерөнхий календарчилсан төлөвлөгөө (хичээлийн жилийн, улирлын, шалгалтын, амралтын эхлэх дуусах хугацаа, төгсөлтийн ажил хамгаалах болон нийтээр амрах баярын өдрүүд);

4.1.3. Оюутан сонгосон хичээлийн явц болон нийт суралцсан хугацааны дүн, сургалтын төлбөрийн мэдээллийг “Оюутны програм”-аас өөрийн кодоор орж авч болно.

- 4.1.4. Нэг багц цагийн хэмжээ өдрийн хэлбэрээр суралцаж байгаа суралцагчийн 7 хоногийн бүтэн ачаалал буюу 40 цагтай тэнцүү байх бөгөөд үүнд танхимд хичээллэх болон бие даан суралцах, шалгалтанд бэлтгэх, шалгалт өгөх цагууд багтана.
 - 4.1.5. Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл тус бүр хөтөлбөртэй байх ба түүнд тухайн хичээлийн агуулгын стандарт тодорхойлогдсон байна.
 - 4.1.6. Багш хичээлийн хөтөлбөрт тодорхойлогдсон агуулгыг оюутанд бүрэн олгох, оюутан тэрхүү агуулгыг эзэмших үүрэгтэй.
 - 4.1.7. Сургалтын төлөвлөгөө нь заавал үзэх хичээлээс гадна сонгон судлах хичээлүүдийг багтаасан байх ба оюутан залгамж холбооны дагуу санал болгох төлөвлөгөөг үндэслэн хичээл сонголт хийнэ.
- 4.2. Өдрийн сургалт
- 4.2.1. Өдрийн хэлбэрээр суралцагч оюутны хугацаа дунджаар дөрвөн жил байх бөгөөд оюутан нэмэлт сургалтанд хамрагдах замаар хичээлүүдээ урьдчилан судалж, төгсөх оюутны шаардлагыг бүрэн хангасан нөхцөлд дөрвөн жилээс богино хугацаанд төгсөж болно.
 - 4.2.2. Оюутан сургалтын хөтөлбөрөөр эхний 1.5-2.0 жилийн хугацаанд суралцан ерөнхий болон мэргэжлийн суурь хичээлүүдийг судалж, зохих багц цаг цуглуулсны дараа сурлагын амжилтаар эрэмблэгдэн тухайн хөтөлбөр дэх өөрийн хүссэн мэргэжлээ сонгон суралцана.
 - 4.2.3. Хичээлийн жил нь үндсэн дөрвөн улирал (I, II, IV, V), нэмэлт хоёр улирал (III, VI)-аас бүрдэнэ. Үндсэн улирал тус бүр найман долоо хоног үргэлжлэх ба тухайн улиралд оюутан санал болгох төлөвлөгөөнд тусгагдсан сургалтын үйл ажиллагаанд оролцоно. Үндсэн улирал хоорондын нэг долоо хоногт шалгалт авч, дүн баталгаажуулна. Нэмэлт улирлын үргэлжлэх хугацаа 4 долоо хоног байна.
 - 4.2.4. Нэмэлт улиралд оюутан хичээлээ түрүүлж судлах, дүнгээ ахиулах, хангалтгүй үнэлгээ авсан хичээлийг дахин судлах зэрэг сургалт зохион байгуулагдана.
 - 4.2.5. Өдрийн хэлбэрээр суралцагч оюутан суралцах хугацаандаа улирал тутам дунджаар 9-өөс илүүгүй багц цагийн хичээлийг судлахаар сонголт хийнэ. Сургалтын албаны зөвшөөрөлтэйгээр ноормоос илүү ачаалалтай байж болно.
 - 4.2.6. Оюутан тухайн улиралд судлах хичээлийн багц цагийн төлбөрийг бүрэн төлснөөр “Хичээл сонголт 1” баталгаажих бөгөөд түүнд үндэслэн гаргасан хичээлийн хуваариас “Хичээл сонголт 2” –г хийснээр тухайн улирлын хичээлийг судлах эрх үүснэ.
 - 4.2.7. Хичээлийн жил эхлэх үед тухайн хичээлийн жилийн хичээл, шалгалтын хуваарь нарийвчлагдаж гарсан байна.

- 4.2.8. Нэмэлт сургалтад хамрагдахаар өргөдөл² гаргасан оюутны хичээл сонголтыг үндэслэн, бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба хуваарь гаргаж, нэмэлт сургалт зохион байгуулна.
- 4.2.9. Нэмэлт сургалтад хамрагдах оюутны нэрсийг бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна.
- 4.2.10. Нэг удаагийн нэмэлт сургалтаар оюутны сонгон судлах хичээлийн нийт багц цаг нь 6-аас ихгүй байна.
- 4.3. Эчнээ сургалт
- 4.3.1. Бүрэлдэхүүний сургуулиуд жил бүр эчнээ сургалт зохион байгуулах нэгдсэн хуанли гаргаж мөрдөнө.
- 4.3.2. Суралцагчдын нэг удаагийн цугларалтад танхимд хичээллэх хугацаа нь 8 долоо хоногоос багагүй байна. Суралцаж буй оюутан нь 4.5 жилийн ангид 5-аас доошгүй, 2.5 жилийн ангид 4-өөс доошгүй удаа тус тус цуглана.
- 4.3.3. Эчнээгээр суралцагчдын судлах хичээлийн нийт багц цаг нь дараах хүснэгтэд зааснаас доошгүй байх ба сургалтын хугацаанаас хамааран ялгаатай байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Эчнээ сургалтын агуулгын багтаамж, хугацаа

Сургалтын хугацаа	Багц цаг			
	Боловсролын суурь	Мэргэжлийн суурь	Мэргэжлийн	Нийт
4.5 жил	30	25	45	120
2.5 жил		25	35	60

- 4.4. Зайн сургалт
- 4.4.1. Элсэлтийн шаардлага ханган шинээр элссэн оюутныг бүртгэж, сургалтанд ашиглах Веб хуудас болон бусад сургалтын бааз руу нэвтрэх хэрэглэгчийн эрх олгоно.
- 4.4.2. Зайн сургалт нь видео сургалт, онлайн сургалт, радио, телевиз, мобайл гэх мэт хэлбэрүүдээр явагдана.
- 4.4.3. Бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албадууд тухайн мэргэжлийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл бүрээр оюутны бие даах ба танхимд заавал суралцах хугацаа, сорил, улирлын шалгалтын талаар нэмэлт мэдээлэл өгч сургалтыг зохион байгуулна.
- 4.4.4. Мэргэжлийн тэнхим нь сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл бүрээр зайн сургалтын үед шаардагдах материалыг (ном, сурах бичиг, CD, гарын авлага, Веб хуудас, хэрэглээний програм хангамж, аудио видео бичлэг гэх мэт) бэлэн болгосон

² Нэмэлт сургалтанд хамрагдах оюутны өргөдлийн загварыг Хавсралт 2-г харуулав.

байхаас гадна, е-хичээлийг “Электрон хичээлийг үнэлэх, хүлээн авах комисс”-оор хэлэлцүүлж, сургалт явуулах эрх авсан байна.

4.4.5. Зайн сургалтаар суралцаж буй оюутны мэдлэгийг нэг улиралд 3-аас доошгүй удаа сорилоор шалгах ба улирлын эцэст хичээл бүрээр улирлын шалгалт авна.

4.4.6. Оюутан нь “Сургалтын нэгдсэн хуанли”-д заасан хугацаанд, бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын алба болон тухайн хичээлийг харъяалан зааж буй мэргэжлийн тэнхим дээр заавал өөрийн биеэр хүрэлцэн ирж явцын сорилд хуваарийн дагуу орно.

4.5. Хавсарга, хос хөтөлбөрийн сургалт

4.5.1. Хавсарга, хос хөтөлбөрийн түвшний сургалтын агуулгын багтаамж, норматив хугацааг элсэгчдийн боловсролын түвшин, суралцах хэлбэрээс хамааруулан дараах байдлаар тогтооно.

Хүснэгт 2. Хавсарга, хос хөтөлбөрийн агуулгын багтаамж, хугацаа

Хөтөлбөр		Өдөр		Орой		Эчнээ	
		Багц цаг	жил	Багц цаг	жил	Багц цаг	Жил
Хавсарга хөтөлбөр		24-өөс багагүй	1 хүртэл	24-өөс багагүй	1 хүртэл	24-өөс багагүй	1.5 хүртэл
Хос хөтөлбөр	ижил чиглэл	40-өөс багагүй	2 хүртэл	40-өөс багагүй	2 хүртэл	40-өөс багагүй	1.5 хүртэл
	өөр чиглэл	60-аас багагүй	3 хүртэл	60-аас багагүй	3 хүртэл	60-аас багагүй	3.5 хүртэл

Тайлбар: - Ижил чиглэл гэдэгт өмнө нь эзэмшсэн болон суралцаж буй мэргэжлийн индексийн эхний 2 орон, бакалаврын зэргийн чиглэл, нэршил ижил байх, эсвэл сурч байгаа хөтөлбөрийн чиглэл ижил тохиолдлыг харгалзан үзнэ.

4.5.2. Хавсарга, хос хөтөлбөрөөр суралцах хүсэлт гаргагч нь үндсэн мэргэжлийн хөтөлбөрөөрөө 1.5 жилээс багагүй хугацаанд 45-аас доошгүй багц цаг судалсан байх шаардлагатай.

4.6. Хос дипломын сургалт

4.6.1. Олон улсын хамтарсан хөтөлбөрүүдэд суралцах элсэгч нь элсэлтийн журамд заасны дагуу өөрийн сонирхсон мэргэжлээр суралцахын зэрэгцээ гадаад хэлний нэмэлт сургалтад хамрагдана.

4.6.2. Гадаад хэлний нэмэлт сургалтад хамрагдсан оюутан зохих болзлыг хангасан тохиолдолд хамтын ажиллагаатай гадаадын их, дээд сургуульд хос хөтөлбөрөөр элсэн суралцах боломжтой.

4.6.3. Хос хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээнд хэлний төрөл, түвшин болон харилцан дүйцэх хичээлийн тоо, үнэлгээний минимум шаардлагыг тогтоосон байна. Үүнд: 60-аас

доошгүй багц цаг цуглуулсан, хэлний хувьд ярианы болон бичгийн зохих мэдлэгтэй, голч дүн 3.0-аас дээш байна.

- 4.6.4. Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр, хамтын ажиллагааны хөтөлбөрийн дагуу гадаадын их, дээд сургууль, коллежид суралцах оюутныг сонгон шалгаруулахад БСШУ-ны сайдын тушаалаар батлагдсан “Гадаадад суралцах оюутныг сонгон шалгаруулах журам”-ыг баримтлана

Тав. Шилжилт, хөдөлгөөн

5.1. Оюутанд чөлөө олгох

- 5.1.1. Оюутан нь тодорхой хүндэтгэн үзэх шалтгааны улмаас чөлөө авч болох ба цагийн чөлөөг тухайн хичээл зааж буй багш, нэг долоо хоног хүртэлх хугацаатай чөлөөг тэнхимийн эрхлэгч, нэг сар хүртэлх хугацаатай чөлөөг сургалт эрхэлсэн орлогч захирал, нэг сараас дээш хугацааны чөлөөг бүрэлдэхүүн сургуулийн захирал олгоно. Тэнхимийн эрхлэгч, сургалт эрхэлсэн орлогч захирал, бүрэлдэхүүн сургуулийн захирлаас чөлөө авахдаа бичгээр өргөдөл³ гаргана.
- 5.1.2. Оюутан улирлын чөлөөтэй байх хугацаандаа өмнө нь хангалтгүй үнэлгээ авсан хичээлийг дахин сонгож судлах эрхтэй.
- 5.1.3. Улирлын болон жилийн чөлөө авсан оюутны төрийн сангийн зээл, буцалтгүй тусламж, үндэсний тэтгэлгийг түр хугацаагаар зогсоож, холбогдох материалыг төрийн санд хүргүүлнэ.
- 5.1.4. Улирлын болон жилийн чөлөөнөөс ирж байгаа оюутан улирлын эхэнд үргэлжлүүлэн суралцах өргөдлөө⁴ сургалтын албанд бичгээр гаргаж, “Хичээл сонголт 1”, “Хичээл сонголт 2”-г сургалтын нэгдсэн хуанлийн хугацаанд хийнэ.

5.2. ХААИС-д шилжин суралцах

- 5.2.1. Шилжилт хөдөлгөөнийг үндсэн улирлын 1 дэх долоо хоногт багтаан хийнэ.
- 5.2.2. Гадаад болон дотоодын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулиудаас ХААИС-д шилжин ирж суралцах хүсэлтэй оюутнууд бүрэлдэхүүн сургуулийн захиралд хандаж бичгээр өргөдөл⁵ гаргана.
- 5.2.3. Бүрэлдэхүүн сургуулийн захирал доорх шаардлага хангасан оюутныг шилжүүлэн суралцуулах зөвшөөрөл олгоно. Үүнд:
1. Элсэлтийн ерөнхий шалгалтын чиглэл тохирч байх;
 2. Анх элсэн орсон мэргэжлээр нэг улирал буюу түүнээс дээш хугацаагаар тасралтгүй суралцсан байх;
 3. Суралцсан хугацааны нийт хуримтлуулсан үнэлгээний голч дүн нь 2.0-оос доошгүй байх;

³ Чөлөө авах өргөдлийн загварыг Хавсралт 3-т харуулав.

⁴ Үргэлжлүүлэн суралцах тухай өргөдлийн загварыг Хавсралт 4-т харуулав.

⁵ Шилжин суралцах тухай өргөдлийн загварыг Хавсралт 5-д харуулав.

4. Дүйцүүлсэн нийт багц цагийн зөрүү 12-оос ихгүй байх;
- 5.2.4. Шаардлага хангасан шилжин ирэх хүсэлтэй оюутан дараах материалыг бүрдүүлнэ.
Үүнд:
1. Шилжин суралцах оюутны хувийн өргөдөл;
 2. Иргэний үнэмлэхийн батлагаажуулсан хуулбар;
 3. Суралцаж байсан сургуульд анх элсүүлсэн захирлын тушаал;
 4. Ерөнхий шалгалтын батламж;
 5. Суралцах эрхийн бичгийн (томилолт) баталгаажуулсан хуулбар;
 6. Суралцсан хугацааны дүнгийн тодорхойлолт;
 7. Өмнө нь суралцаж байсан сургуулиас шилжүүлэн суралцахыг зөвшөөрсөн захирлын албан бичиг, тодорхойлолт;
 8. Гадаадын их, дээд сургуулиас шилжин ирэх хүсэлтэй оюутны хувьд өмнөх сургуульд суралцаж байсан тухай албан бичиг болон дүнгийн тодорхойлолтыг орчуулгын товчоогоор орчуулуулан баталгаажуулж, эх хувийн хамт;
 9. Бүрэн дунд боловсролын гэрчилгээ, хувийн хэрэг;
- 5.2.5. Бүрэлдэхүүн сургуулийн сургалт эрхэлсэн орлогч захирал шилжин суралцах зөвшөөрөл олгогдсон оюутны дүнгийн жагсаалт дахь өмнө нь үзэж судалсан хичээлүүдийг мэргэжлийн сургалтын төлөвлөгөөтэй агуулгын хувьд дүйцүүлэн тооцож, зөрүү багц цагийн төлбөр төлүүлж “ХААИС-ийн оюутны суралцах гэрээ” байгуулна.
- 5.2.6. “ХААИС-ийн оюутны суралцах гэрээ” байгуулсан оюутныг бүртгэж, оюутны код олгосноор тухайн оюутан “Хичээл сонголт 1, 2”-г хийж суралцах эрхтэй болно.
- 5.2.7. Төгсөх ангид оюутан шилжүүлэн суралцуулахыг хориглоно.
- 5.3. ХААИС-иас шилжүүлэх
- 5.3.1. Оюутан шилжин суралцах хүсэлтээ бүрэлдэхүүн сургуулийн сургалт эрхэлсэн орлогч захиралд хандаж өргөдөл⁶ гаргана.
 - 5.3.2. ХААИС-иас шилжих оюутан нь тойрох хуудас бөглүүлж, төлбөр тооцоогоо бүрэн дуусгасан байна.
 - 5.3.3. Оюутныг шилжүүлэхтэй холбоотой төлбөр тооцоо нь “ХААИС-ийн санхүүгийн журам”, “ХААИС-ийн оюутны суралцах гэрээ”-ээр зохицуулагдана.
- 5.4. Оюутныг сургуулиас чөлөөлөх
- 5.4.1. Сургуулийн захиргаанаас дараах тохиолдолд оюутантай байгуулсан “Бакалаврын сургалтын гэрээ” -г цуцалж, сургуулиас чөлөөлнө. Үүнд:
 1. ХААИС-ийн оюутны ёс зүйн дүрмийг ноцтой зөрчсөн;
 2. “ХААИС-ийн оюутны суралцах гэрээ”-ний заалтыг ноцтой зөрчсөн;

⁶ Шилжин явах, сургуулиас гарах тухай өргөдлийн загварыг Хавсралт 6-д харуулав.

3. ХААИС-ийн хичээлийн болон оюутны байр, орчин тойронд архи, согтууруулах ундаа хэрэглэсэн;
4. Мансууруулах бодис хэрэглэсэн, хадгалсан, худалдаалах, дамжуулахад оролцсон;
5. ХААИС-ийн дүрэм, дотоод журмыг зөрчиж гэмт хэрэг, ёс зүйн ноцтой зөрчил гаргасан нь нотлогдсон;
6. Захирлын тушаалд заасан хугацаанд чөлөөнөөс ирж, үргэлжлүүлэн суралцаагүй;
7. Шүүхээр гэм буруутай нь тогтоогдоод ял эдлэхээр заагдсан;
8. Оюутан өөрөө сургуулиас гарахыг хүссэн;⁶
9. Оюутны суралцсан хугацааны үнэлгээний голч дүн 0.7-оос бага, эсвэл “Анхааруулах хуудас”⁷-ыг 3 удаа давтан авсан;

Зургаа. Оюутны мэдлэг, чадвар, хандлагыг дүгнэх

6.1. Стандарт үнэлгээ

- 6.1.1. Оюутны мэдлэг, чадвар, хандлагыг дүгнэхдээ тэдний бие даан суралцах үйл ажиллагааг хөхиүлэн дэмжин хөгжүүлэх, оюутны сурах, багшийн сургах үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх, үнэлгээний дүн бодитой, үнэмшилтэй, ил тод байх зарчмыг удирдлага болгоно.
- 6.1.2. Оюутны мэдлэг, ур чадвар, хандлагыг дүгнэх арга, хэлбэр нь хичээлийн стандарт хөтөлбөрт тусгагдсан байх ба Хүснэгт 3-т заасан стандарт үнэлгээг хэрэглэнэ.
- 6.1.3. Багш оюутнуудын үнэлгээг үндсэн улирлын 9 дэх, нэмэлт улирлын 5 дахь долоо хоногт багтаан “Сургалтын програм”-д оруулах ба оюутан “Оюутны программ”-д нэвтэрч үнэлгээтэй танилцана.
- 6.1.4. Хичээл заасан багш дүнгийн хуудсаа тухайн улирлын шалгалт авах, дүн тооцох долоо хоногт багтаан сургалтын програмаас хэвлэн гаргаж, сургалтын менежерээр баталгаажуулсан байна.
- 6.1.5. Оюутны сурлагын чанарыг харуулах гол үзүүлэлт нь үнэлгээний голч дүн (ҮГД) мөн. ҮГД-г оюутны суралцах хугацааны хөтөлбөрийн агуулга эзэмшилтийн чанарын түвшинг дараах (1) томъёогоор тооцно.

$$\text{ҮГД} = \frac{\sum_{i=1}^n k_i \cdot o_i}{\sum_{i=1}^n k_i} \quad (1)$$

Үүнд: k_i – тухайн хичээлийн багц цаг;

o_i – тухайн хичээлийн рейтингийн дүнд харгалзах чанарын оноо;

n – суралцах хугацаанд судалж, стандарт үнэлгээ авсан хичээлийн тоо;

- 6.1.6. Оюутан F үнэлгээ авсан тохиолдолд нэмэлт сургалт болон тухайн хичээл орох улиралд дахин судалж үзнэ.

⁷ Анхааруулах хуудасны загварыг Хавсралт 7-т харуулав.

Хүснэгт 3. Оюутны мэдлэгийн түвшинг үнэлэх стандарт үнэлгээ

№	Үнэлгээний хувь	Үсгэн үнэлгээ	Үнэлгээний голч оноо
1	96.0-100	A	4.0
2	90.0-95.9	A-	3.7
3	87.0-89.9	B+	3.4
4	83.0-86.9	B	3.0
5	80.0-82.9	B-	2.7
6	77.0-79.9	C+	2.4
7	73.0-76.9	C	2.0
8	70.0-72.9	C-	1.7
9	67.0-69.9	D+	1.4
10	63.0-66.9	D	1.0
11	60.0-62.9	D-	0.7
12	0-59.9	F	0.0

6.2. Стандарт бус үнэлгээ

- 6.2.1. Хичээл сонголт хийгдэж, “Сургалтын програмд” нэр нь орсны дараа тухайн хичээлийг судлаагүй эсвэл шалгалт өгөөгүйгээс шалтгаалж оюутанд R, W, S, U гэсэн стандарт бус үнэлгээ ашиглаж болно.
- 6.2.2. R (repeat) – тухайн хичээлийг дахин судлахаар шийдсэн. Оюутан тухайн хичээлийг дахин судлах хүсэлт гаргасан тохиолдолд “R” үнэлгээг дүнгийн хуудаст тавиулж болно. Улирлын эхний долоо хоногт багтан бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанд “R” үнэлгээ тавиулах өргөдлөө баталгаажуулсан тохиолдолд тухайн хичээлийг төлбөр төлөхгүйгээр дахин сонгож судлах эрхтэй.
- 6.2.3. W (withdraw) – хичээлийн явцад суралцахаас татгалзаж хаясан. Улирлын эхний долоо хоногт багтааж бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанд “R” үнэлгээ тавиулах өргөдлөө баталгаажуулаагүй тохиолдолд “W” тэмдэглэгээ авч тухайн хичээлийн багц цагийн төлбөрийг 100% төлж дахин сонгож судлана.
- 6.2.4. S (satisfied) – тооцов, U (unsatisfied) – үл тооцов үнэлгээнүүдийг багц цаг тооцох шаардлагагүй шалгалт, ангийн ажил, оюутны мэргэжлийн мэдлэг, чадварыг илэрхийлэхгүй зарим хичээлүүдэд ашиглаж болно.

6.2.5. Оюутан R, W стандарт бус үнэлгээ авсан тохиолдолд ангийн ажлаа дахиж хамгаалах, шалгалтаа дахиж өгөх, хичээлээ дахин судлах замаар стандарт үнэлгээ болгуулах эсвэл U стандарт бус үнэлгээ тавигдсан бол S үнэлгээ болгож өөрчлүүлэх үүрэгтэй.

6.3. Хичээлийн үнэлгээг шууд тооцох

6.3.1. Тухайн хичээлийг сонгосон боловч хичээлд суухгүйгээр улирлын шалгалтаа шууд өгч стандарт үнэлгээ авах хүсэлтэй оюутан улирлын эхний долоо хоногт тухайн хичээлийн багц цагийн үнэлгээний 30 хувийн төлбөрийг төлж, холбогдох сургуулийн сургалтын албанд өргөдөл гарган шалгалт өгч болно. Шууд тооцох шалгалт нь зөвхөн сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь хэсэг дэх гадаад хэл, мэдээллийн технологийн хичээлд зөвшөөрөгдөнө.

6.3.2. Багц цаг шууд тооцох шалгалтыг оюутан амжилттай өгсөн тохиолдолд тухайн хичээлд зохих стандарт үнэлгээ тавигдана.

6.3.3. Оюутан нь нэг хичээлийн жилд 3 хүртэлх хичээлээр багц цаг шууд тооцох шалгалт өгөх эрхтэй.

6.3.4. Оюутан багц цаг шууд тооцох шалгалтын үр дүнг хангалтгүй гэж үзвэл тухайн хичээлийг шинээр сонгож судлах шаардлагатай.

6.3.5. Оюутны сонгуульт ажил, хичээлээс гадуур зохиогдох соёл, спорт, хүмүүжил, олон нийтийн ажил, улсын болон олон улсын мэргэжлийн олимпиадад амжилт гаргасан зэргийг харгалзаж холбогдох хичээлүүдийн стандарт үнэлгээг их сургуулийн болон бүрэлдэхүүний сургуулийн захирлын тушаалыг үндэслэн урамшуулал хэлбэрээр шууд тооцож болно.

Долоо. Оюутныг урамшуулах

7.1. ХААИС-ийн Захирлын нэрэмжит батламж

7.1.1. Сургалтын нэгдсэн хуанлийн хоёр улирлын нийлбэр дүнгээр 3.7 ба түүнээс дээш голч дүнтэй суралцсан оюутанд “ХААИС-ийн Захирлын нэрэмжит батламж” олгож, сургуулийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

7.1.2. “ХААИС-ийн Захирлын нэрэмжит батламж”⁸-ийг дараах болзлуудыг хангасан оюутанд жилд 2 удаа олгоно. Үүнд:

1. Сургуулийн дүрэм, дотоод журам зөрчөөгүй;
2. Бакалаврын сургалтын гэрээг зөрчөөгүй;
3. Улирал тутамд цуглуулсан багц цаг 6-аас дээш;

7.1.3. “ХААИС-ийн Захирлын нэрэмжит батламж”-ийг дараалан гурван удаа хүртсэн оюутан тухайн жилийн сургалтын төлбөрийг 20 хувиар хөнгөлүүлэх эрх эдэлнэ.

⁸ Захирлын нэрэмжит батламжийн загварыг Хавсралт 8-д харуулав.

7.2. ХААИС-ийн Захирлын нэрэмжит тэтгэлэг

7.2.1. Хичээлийн жилийн эцэст сурлага, спорт, урлаг, хөдөлмөрийн өндөр амжилт гарган суралцсан тэргүүний оюутанд “ХААИС-ийн Захирлын нэрэмжит тэтгэлэг” олгож, нийтэд сурталчилна.

7.2.2. “ХААИС-ийн Захирлын нэрэмжит тэтгэлэг”-ийг дараах болзлуудыг бүрэн хангасан оюутанд жилд нэг удаа олгоно. Үүнд:

1. Дараалан дөрвөн удаа Захирлын нэрэмжит батламж авсан;
2. Бакалаврын сургалтын гэрээг зөрчөөгүй;
3. Улсын болон олон улсын чанартай мэргэжлийн олимпиад, оюутны эрдэм шинжилгээний бага хуралд оролцож байр эзэлсэн;
4. Сургууль, олон нийтийн ажилд идэвх санаачлагатай оролцсон;

7.2.3. “ХААИС-ийн Захирлын нэрэмжит тэтгэлэг”-ийг батламж, энгэрийн тэмдэг, цом, тухайн жилийн сургалтын төлбөрөөс 50 хүртэл хувиар хөнгөлүүлэх эрх тус тус дагалдана.⁹

7.2.4. “ХААИС-ийн Захирлын нэрэмжит тэтгэлэг”-ийг хичээлийн жилийн эхэнд гардуулна.

7.3. Бүрэлдэхүүн сургуулийн шилдэг оюутан

7.3.1. Сурлагын тогтвортой амжилт гарган суралцаж байгаа, олон улс, улсын чанартай олимпиадад, спортын, урлагийн уралдаан, тэмцээнд онцгой амжилт гаргасан оюутныг тухайн бүрэлдэхүүн сургуулийн оны шилдэг оюутан болон шилдэг төгсөгч оюутнаар өргөмжилнө.

7.3.2. Оны шилдэг оюутныг дараах төрлүүдээр шалгаруулж, оны эцэст шагнаж, урамшуулна. Үүнд:

1. Оны шилдэг сурлагатан оюутан;
2. Оны шилдэг судлаач оюутан;
3. Оны шилдэг хөдөлмөрч оюутан;
4. Оны шилдэг тамирчин оюутан;
5. Оны шилдэг авьяаслаг оюутан;
6. Оны шилдэг хамт олон;

7.3.3. Оны шилдэг оюутнууд дараах давуу эрхүүдийг эдлэх болно. Үүнд:

1. төрөл бүрийн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах;
2. гадаадын их, дээд сургуульд элсэн суралцахад тэргүүн ээлжинд тодорхойлуулах;
3. гадаадын хамтын ажиллагаатай их сургуулиудад хос хөтөлбөрөөр сурах;
4. хэлний болон тусгай мэргэжлийн сургалтад хамрагдах;
5. магистрантурт хөнгөлөлттэй нөхцөлөөр элсэх;
6. бүрэлдэхүүн сургуульд багшлах, харъяа эрдэм шинжилгээний байгууллагад эрдэм шинжилгээний ажил хийх;

⁹ Захирлын нэрэмжит тэтгэлэгийн батламж, энгэрийн тэмдэг, цомны загварыг Хавсралт 9-т харуулав.

7.3.4. Шилдэг төгсөгч оюутныг шалгаруулахад суралцах хугацааны сурлага, хөдөлмөрийн амжилтыг үндэслэх бөгөөд төгсөлтийн баяр дээр шагнаж, урамшуулна.

7.3.5. Шилдэг төгсөгч оюутнууд дараах давуу эрхүүдийг эдлэх болно. Үүнд:

1. магистрантурт хөнгөлөлттэй нөхцөлөөр элсэх;
2. бүрэлдэхүүн сургууль, харъяа эрдэм шинжилгээний байгууллагад ажиллах;

7.3.6. Оны шилдэг болон шилдэг төгсөгч оюутанд гэрчилгээ, тууз олгоно.¹⁰

Найм. Эрдэм шинжилгээний ажил

8.1. Эрдэм шинжилгээний ажлын зохион байгуулалт

8.1.1. Бакалаврын оюутны эрдэм шинжилгээний ажлын төлөвлөлт, зохицуулалтыг тэнхим, бүрэлдэхүүний сургууль, харъяа хүрээлэнгүүдээр дамжуулан гүйцэтгэнэ.

8.1.2. Бакалавр оюутны эрдэм шинжилгээний ажилд удирдагч багшийн тусламжтайгаар гүйцэтгэж байгаа илтгэл, өгүүлэл, ангийн ажил, сургалтын болон үйлдвэрлэлийн дадлагын тайлан, төгсөлтийн ажил зэргийг хамруулж ойлгоно.

8.1.3. Бакалавр оюутны эрдэм шинжилгээний ажлыг шинжлэх ухаан технологийн төсөл, сэдэв, мэргэжлийн тэнхим, хүрээлэнгүүдийн лаборатори, сургалт, туршилтын нэгж зэргийг түшиглэн гүйцэтгэхээр төлөвлөж ажиллана.

8.1.4. Бакалавр оюутны эрдэм шинжилгээний ажлын нэгдсэн бүртгэл, хяналт, зохицуулалтыг бүрэлдэхүүн сургуулийн эрдэм шинжилгээ эрхэлсэн орлогч захирал хариуцан ажиллана.

8.1.5. Оюутан мэргэжлээ сонгосны дараа харъяалах тэнхим нь эрдэм шинжилгээний удирдагч багш, судалгааны чиглэлийг өөрсдөөр нь сонгуулж, бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна.

8.1.6. Оюутны эрдэм шинжилгээний ажлын удирдагч багш нь эрдэм шинжилгээ хийх арга зүй эзэмшүүлэх, илтгэл бэлдэх, өгүүлэл бичих улмаар бакалаврын төгсөлтийн ажлаа цэгцлэн бичихэд туслах үүрэг хүлээнэ.

8.1.7. Оюутны сонгосон сэдвээр судалгаа явуулах арга зүйг тухайн салбарын эрдэмтдийн төлөөлөл оролцсон хөтөлбөрийн хорооны өргөтгөсөн хурлаар хэлэлцэж батална.

8.1.8. Бакалаврын оюутны эрдэм шинжилгээний ажлыг дараах хэлбэрээр зохион байгуулж болно. Үүнд:

1. Сургууль, хүрээлэнгээс гүйцэтгэж байгаа шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь судалгааны ажил, гэрээт ажилд оролцох;
2. Зохион бүтээх, технологи боловсруулах эрдэм шинжилгээний дугуйланд тусгай батлагдсан хөтөлбөрийн дагуу хичээллэх;

¹⁰ Шилдэг оюутны гэрчилгээ, тууз, энгэрийн тэмдгийн загварыг Хавсралт 10-т харуулав.

3. Мэргэжлийн тэнхим, салбараас баталсан арга зүйн дагуу лабораторийн болон хээрийн туршилт хийх, батлагдсан тодорхой сэдвээр шинжлэх ухааны мэдээлэл хайх, цуглуулах, боловсруулах, дүгнэлт хийх;
4. Судалгааны ажлын үр дүнгээр ХААИС, бусад мэргэжлийн болон олон нийтийн байгууллагаас зарласан эрдэм шинжилгээний бага хуралд оролцон илтгэл тавьж хэлэлцүүлэх, чиглэлийн салбар шинжлэх ухааны сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх;
5. Сургалтын болон үйлдвэрлэлийн дадлагын хүрээнд арга зүй эзэмшиж, судалгаа хийх;

8.1.9. Журмын 8.1.7-д заасан болон бусад төрлийн аливаа эрдэм шинжилгээний ажил нь тухайн оюутны төгсөлтийн ажилтай уялдах ба төгсөлтийн ажлынхаа 30 хувийг сургалтын дадлага, 40 хувийг үйлдвэрлэлийн дадлагатай хамт, үлдсэн 30 хувийг хамгаалахын өмнөхөн хийж дуусгахаар төлөвлөнө.

8.1.10. Бакалаврын оюутны эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийн чанар, үр дүнг мэргэжлийн хөтөлбөрийн хороо болон бүрэлдэхүүний сургуулийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж, зохих шийдвэр гаргаж ажиллана.

8.2. Бакалаврын оюутны эрдэм шинжилгээний ажлыг дүгнэж урамшуулах

8.2.1. Эрдэм шинжилгээний ажлыг хөхүүлэн дэмжих, урамшуулах зорилгоор оюутны шилдэг илтгэл шалгаруулах ажлыг жил бүр эрдэм шинжилгээний бага хурал хэлбэрээр 3 үе шаттай зохион байгуулна.

8.2.2. Эрдэм шинжилгээний анхан шатны бага хурлыг мэргэжлийн тэнхим 3 дугаар сарын эхээр, хоёр дахь шатныг бүрэлдэхүүний сургууль, хүрээлэнгүүд 3 дугаар сарын сүүлийн хагаст, сүүлийн шатны хурлыг Шинжлэх ухааны зөвлөл 4 сарын эхний хагаст багтаан жил бүр зохион байгуулна.

8.2.3. Гуравдугаар шатны хурлын комиссын бүрэлдэхүүнд шинжлэх ухааны зөвлөл, гадаад хамтын ажиллагааны алба, сургалтын бодлого зохицуулалтын алба, бүрэлдэхүүний сургууль, харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгийн төлөөллийг оролцуулна.

8.2.4. Илтгэлийг шалгаруулахдаа дараах үзүүлэлтүүдийг харгалзан үзнэ. Үүнд:

1. Сэдвийн ач холбогдол;
2. Туршилт, судалгааны арга зүй эзэмшсэн байдал;
3. Тухайн салбарын онол, практикийн мэдлэг;
4. Судалгааны ажилд орчин үеийн програм хэрэгсэл ашигласан байдал;
5. Илтгэх ур чадвар;

8.2.5. Их сургуулийн хэмжээний оюутны эрдэм шинжилгээний бага хуралд тавигдсан илтгэлүүдээс эхний гурван байрыг дараах байдлаар урамшуулна. Үүнд:

- 1-р байр нэг, өргөмжлөл, мөнгөн шагнал;
- 2-р байр хоёр, өргөмжлөл, мөнгөн шагнал;

3-р байр хоёр, өргөмжлөл, мөнгөн шагнал;

8.2.6. ХААИС-ийн оюутны эрдэм шинжилгээний нэгдсэн бага хуралд шалгарч оролцсон оюутныг гадаад, дотоодын төрөл бүрийн тэтгэлэгт хамруулахад бүрэлдэхүүний болон их сургуулийн зүгээс нэн тэргүүн ээлжинд тодорхойлж дэмжлэг үзүүлнэ.

Ес. Төгсөлтийн үйл ажиллагаа

- 9.1. Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдийг бүрэн судалж хангалттай үнэлгээ авсан, үнэлгээний голч дүн 2-оос дээш, сургалтын төлбөрөө зуун хувь төлж барагдуулсан оюутан төгсөгчөөр бүртгэгдэнэ.
- 9.2. Төгсөлтийг жилд 2 удаа “ХААИС-ийн сургалтын нэгдсэн хуанли”-д заасан хугацаа, сургалтын төлөвлөгөө, явцын графикийг харгалзан зохион байгуулна.
- 9.3. Тус журмын 8.1.4, 8.1.6-т заасны дагуу оюутан бүр төгсөлтийн ажил хамгаална.
- 9.4. Төгсөлтийн ажил бичих, хамгаалах удирдамж нь мэргэжлийн онцлогоос хамаарч ялгаатай байж болно.
- 9.5. Төгсөлтийн ажил хамгаалуулах салбар комисс нь тухайн мэргэжлийн хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүн байна. Төгсөлтийн ажлын агуулга, чиглэлээс хамаарч өргөтгөсөн комисс байгуулж болно.
- 9.6. Хөтөлбөрийн хорооны зохицуулагч төгсөлтийн ажил хамгаалалтын дүнг сургалтын мэдээллийн системд оруулж баталгаажуулна.
- 9.7. Бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба төгсөлтийн ажил хамгаалах болзол хангасан оюутнуудын нэрсийг Сургалтын бодлого зохицуулалтын албанд уламжлан “Төгсөлтийн ажил хамгаалуулах оюутны нэрсийг батлах тухай” ХААИС-ийн захирлын тушаал гаргуулна.
- 9.8. Бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба төгсөгч оюутнуудын төгсөлтийн ажлаа амжилттай хамгаалсан тухай мэргэжлийн хөтөлбөрийн хорооны шийдвэрийг үндэслэн “Төгсөгчдөд боловсролын зэрэг, мэргэжлийн диплом олгох тухай” ХААИС-ийн захирлын тушаал гаргуулна. Тушаалын төслийн хавсралтанд оюутны овог, нэр, хүйс, регистр, дипломын болон бүртгэлийн дугаарыг тусгасан байна.
- 9.9. Захирлын “Төгсөгчдөд боловсролын зэрэг, мэргэжлийн диплом олгох тухай” тушаал гарсны дараа төгсөгчийн Бакалаврын зэргийн дипломыг хэвлэж, гардуулах ажлыг бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба зохион байгуулна.
- 9.10. Бакалаврын зэргийн диплом нь Монгол Улсын Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас өгсөн дугаар, ХААИС-ийн бүртгэлийн дугаартай байх ба ХААИС-ийн удирдах зөвлөлийн дарга, ХААИС-ийн захирал, төгсөлтийн шалгалтын төв комиссын дарга, бүрэлдэхүүн сургуулийн захирлын гарын үсэг, тамгаар баталгаажсан байна.

Арав. Журмын хэрэгжилтийн хяналт, үнэлгээ

- 10.1. Энэхүү журмын хэрэгжилтэд Сургалтын бодлого зохицуулалтын алба болон бүрэлдэхүүний сургуулийн сургалтын алба тогтмол хяналт тавьж, үнэлгээ хийн, үр дүнг нь сургалтад оролцогч талуудад мэдээлж, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй сайжруулахад ашиглана.
- 10.2. Чанарын баталгаажуулалт, мониторинг, үнэлгээ хариуцсан нэгж, албан тушаалтан хөндлөнгийн үнэлгээ хийж тайланг Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шаардлагатай бол журамд өөрчлөлт оруулж болно.
- 10.3. Журмын хэрэгжилтийн хяналт, үнэлгээг ХААИС-ийн бүтцийн нэгжээс гаргадаг сургалтын бичиг баримт, тайлан, судалгаа, оюутан, багш, ажилтан, төгсөгч, ажил олгогчдыг хамруулсан санал асуулга, хөндлөнгийн шалгалтын дүн зэрэгт тулгуурлан хийнэ.

Хавсралт 1. ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛИЙН ОЮУТНЫ СУРАЛЦАХ ГЭРЭЭ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү гэрээг нэг талаас Хөдөө аж ахуйн их сургууль /цаашид ХААИС гэнэ/-ийг төлөөлж бүрэлдэхүүний сургуулийн захирал _____, нөгөө талаас суралцагч /цаашид оюутан гэнэ/ -ийг төлөөлж хөтөлбөрөөр суралцагч кодтой овогтой нар харилцан тохирч, Монгол Улсын Иргэний хууль, Монгол Улсын Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, ХААИС-ийн дүрэм, журмыг үндэслэн байгуулав.

ХОЁР. ХААИС-ИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 2.1. Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгуулж, төгсөгчдөд зохих шатны мэдлэг, мэргэжил эзэмшүүлэх,
- 2.2. Оюутнуудыг ХААИС-ийн дүрэм болон бусад холбогдох дүрэм, журам, заавруудтай танилцуулах,
- 2.3. Суралцах гэрээг жил бүр шинэчлэн байгуулж, сунгалт хийх,
- 2.4. Суралцах хугацаанд оюутнуудад хичээлийн байр, оюутны дотуур байр, спорт заал, номын сан, интернет үйлчилгээгээр зохих журмын дагуу үйлчлэх,
- 2.5. Суралцах хугацаандаа зохих болзлыг хангасан оюутанд тэтгэлэг олгох асуудлыг захиалагчид болон бусад холбогдох газруудад тавьж шийдвэрлүүлэх,
- 2.6. Сургалтын төлөвлөгөөнд заагдсан хичээлүүдийг бүрэн судалж эзэмшсэн нөхцөлд тухайн мэргэжлээр боловсролын зэрэг, диплом, энгэрийн тэмдэг олгох,

ГУРАВ. ХААИС-ИЙН ЭРХ

- 3.1. Оюутнуудаас суралцах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах,
- 3.2. Оюутан сургалтын төлбөрийг гэрээний хугацаанд төлөөгүй нөхцөлд хичээл сонголт хийлгэхгүй байх,
- 3.3. Гэмт хэрэг, хэв журмын зөрчил гаргасан буюу холбогдсон, архи дан согтуурах, сургуулийн дотоод журам, бусад холбогдох дүрэм, журмыг зөрчсөн тохиолдолд суралцах гэрээг цуцлах,
- 3.4. Оюутны хэт их болон хэт бага багц цагийн хичээл сонголтонд хяналт тавих, хязгаарлах,
- 3.5. Оюутан хүндэтгэн үзэх шалтгаанаар улирал, жилийн чөлөө авч хугацаандаа ирээгүй, чөлөөний хугацааг сунгуулах талаар албан ёсоор мэдэгдээгүй тохиолдолд цаашид суралцуулахгүй байх,
- 3.6. Оюутны ар гэрээс оюутны хүлээх үүрэг буюу уг гэрээний 4.1-4.9 заалтуудтай холбоотой санал, гомдлыг хүлээн авахгүй байх,

ДӨРӨВ. ОЮУТНЫ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 4.1. Сургалтын төлбөрийг хичээлийн жил, улирал бүрийн эхэнд бүрэн төлөх,
- 4.2. Сургалтын төлөвлөгөөнд заагдсан хичээлүүдийг бүрэн үзэж, зохих багц цагийг цуглуулах,

- 4.3. Хичээлийн жилийн нэг үндсэн улиралд 9-өөс дээшгүй багц цагийн хичээл сонгон хэвийн ачаалалтай суралцах,
- 4.4. Сургуулийн захиргаа, сургалтын албанаас гаргасан тушаал, шийдвэрүүдийг биелүүлэх,
- 4.5. Сургууль, тэнхим, багшаас өгсөн үүрэг даалгавар, сургуулийн дотоод журам, дүрмийг хүндэтгэж хатуу чанд мөрдөх.
- 4.6. Оюутан хангалтгүй дүн үзүүлсэн тохиолдолд тухайн хичээлийн багц цагийн төлбөрийг бүрэн төлж дахин судлах,
- 4.7. Явцын болон улирлын шалгалт, сургалт, үйлдвэрлэлийн дадлага, төгсөлтийн ажлыг цаг хугацаанд өгч, хамгаалах,
- 4.8. Улирлын эцэст судалсан хичээлүүдийн дүнг баталгаажуулах,
- 4.9. Сурлагын дүн, хичээлийн ирц, төлбөрийн асуудлаас болж сургуулиас хасагдах болон жилийн чөлөө авах тохиолдолд ар гэртээ мэдэгдэх,

ТАВ. ОЮУТНЫ ЭРХ

- 5.1. Хэвийн суралцах бололцоогоор хангуулах, боловсролын зэргээ ахиулах,
- 5.2. Сургалтын төлөвлөгөөн дэх заавал судлах хичээлээс гадна сонгон хичээлүүдийг сонгон судлах,
- 5.3. Сургалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй хичээлийг сонгон судлах тохиолдолд нэмэлт төлбөр төлж суралцах,
- 5.4. “Захирлын нэрэмжит батламж”-ийг 3 улирал дараалан авсан тохиолдолд сургалтын төлбөрийг 20 хувиар хөнгөлүүлэх,
- 5.5. Багшийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар санал гаргах, шүүмжлэх, шаардлага тавих,
- 5.6. Хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хөнгөлөлт эдлэх,
- 5.7. Оюутны хөгжил, төлөвшилд чиглэсэн үйл ажиллагаа, хөтөлбөрт хамрагдах эрхтэй
- 5.8. Зохих болзол хангасан тохиолдолд гадаадын ижил мэргэжлийн хамтын ажиллагаатай сургуулиудад үргэлжүүлэн суралцах,

ЗУРГАА. САНХҮҮГИЙН ТООЦООНЫ ТАЛААР

- 6.1. Оюутан улирал, жилийн “Хичээл сонголт-1”-д үндэслэн сургалтын төлбөрийг “Хичээл сонголт-2”-оос өмнө заавал төлж багшаа сонгох, хичээлийн хуваариа зохиож хичээлд суух эрхтэй болно.
- 6.2. Төрийн сангийн зээлээр суралцаж байгаа оюутан өөрийн хүсэлтээр мэргэжил солих буюу шилжин суралцсан тохиолдолд сургалтын төлбөрийг төр хариуцахгүй.
- 6.3. Оюутан бүрэлдэхүүний сургууль болон бусад их, дээд сургуульд шилжин суралцах бол жилийн төлбөрийн 20%-тай тэнцэх төлбөрийг тухайн бүрэлдэхүүн сургуулийн дансанд тушаана.
- 6.4. Улирал бүрийн эхний долоо хоногт багтаан суралцагч нь гэрээ цуцлах ба чөлөө хүссэн тохиолдолд өргөдөл гаргасан 7 хоногоор тасалбар болгож, сургалтын төлбөрийн үлдэх хэсгийг буцаан олгоно. Дээрхи хугацаанаас хойш өргөдөл гаргасан тохиолдолд сургалтын төлбөрийг буцаан олгохгүй.
- 6.5. Төлбөрийг бэлнээр болон шилжүүлгээр төлсөн тохиолдолд мөнгө тушаасан баримтын нэг хувийг өөртөө заавал үлдээнэ
- 6.6. Оюутан суралцах хугацааны Сургалтын удирдлагын “ULMS” систем ашиглах эрхийн (4 жилийн) төлбөрийг нэг удаа төлж үйлчилгээний эрхээ нээлгэнэ.
- 6.7. Оюутан нь хүндэтгэх шалтгаангүйгээр дараагийн улиралд судлах “Хичээл сонголт-1”-ийг

заасан хугацаанд хийгээгүй тохиолдолд нэмэлт үйлчилгээний төлбөр 30.000 төгрөгийг бүрэлдэхүүн сургуулийн дансанд тушааж хичээл сонголт хийх эрхээ нээлгэнэ.

ДОЛОО. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ НӨХЦӨЛ

- 7.1. Сургуулийн дотоод журам болон бусад холбогдох дүрэм журмын заалтыг зөрчсөн тохиолдолд цуцална.
- 7.2. “Анхааруулах хуудас” 2 удаа авсан тохиолдолд сурлагаар тэнцээгүйд тооцож гэрээг цуцална.
- 7.3. Нийгмийн хэв журам зөрчсөн, архидан согтуурсан тохиолдолд гэрээг цуцална.
- 7.4. Сургуулийн удирдлага, захиргаанаас өгсөн үүрэг даалгаврыг удаа дараа биелүүлээгүй, оюутны ёс зүйн дүрэм ноцтой зөрчсөн тохиолдолд гэрээг цуцална.

НАЙМ. ГЭРЭЭНИЙ ХҮЧИНТЭЙ БАЙХ ХУГАЦАА

- 8.1. ХААИС нь энэ гэрээний “Хоёр”-т заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд оюутанд учирсан аливаа гэм хорыг зохих хууль, дүрэм, журмын дагуу арилгана.
- 8.2. Энэхүү гэрээг талууд тус бүр нэг хувь хадгална.
- 8.3. Энэ гэрээнд 2 тал гарын үсэг зурсан өдрөөс эхлэн нэг жилийн хугацаанд хүчинтэй.
- 8.4. Гэрээнээс үүссэн маргааныг 2 тал харилцан тохиролцож чадаагүй тохиолдолд хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

/ХААИС/ талыг төлөөлж
Бүрэлдэхүүний сургуулийн захирал

/Суралцагч/ талыг төлөөлж
Оюутан

/Захирлын гарын үсэг, тэмдэг/

/Оюутны гарын үсэг/

20.... оны... сарын -ны өдөр

Гэрээний сунгалт

Хичээлийн жил	Гарын үсэг	
	Захирал	Оюутан
...../.....		
...../.....		
...../.....		
...../.....		

Хавсралт 2. Нэмэлт сургалтанд хамрагдах оюутны өргөдлийн загвар

ХААИС-ийн сургуулийн сургалтын албанд

Өргөдөл гаргах нь

20.... оны ... сарын ...-ний өдөр

Миний бие овогтой нь тус сургуулийн
..... хөтөлбөрөөр кодтой суралцдаг.

.....
.....
шалтгаанаар хичээлийн нэмэлт сургалтанд хамрагдах хүсэлтэй
тул сонголт хийх боломж, хичээлд суух зөвшөөрөл олгоно уу?

Жич. Нэмэлт сургалтын багц цагийн төлбөрийг төлсөн баримтыг хавсаргав.

Оюутан

Харилцах утасны дугаар:

Хавсралт 3. Чөлөө авах өргөдлийн маягт

ХААИС-ийн сургуулийн сургалтын албанд

Өргөдөл гаргах нь

20.... оны ... сарын ...-ний өдөр

Миний бие овогтой нь тус сургуулийн
..... хөтөлбөрөөр кодтой суралцдаг.

.....
.....
шалтгаанаар хоног, сар, улирлын (аль тохирохыг авах) чөлөө
авах хүсэлтэй тул зөвшөөрөл олгоно уу?

Оюутан

Харилцах утасны дугаар:

Хавсралт 4. Үргэлжлүүлэн суралцах тухай өргөдлийн загвар

ХААИС-ийн сургуулийн сургалтын албанд

Өргөдөл гаргах нь

20.... оны ... сарын ...-ний өдөр

Миний бие овогтой нь тус сургуулийн
..... хөтөлбөрөөр кодтой суралцдаг.

.....
..... шалтгаанаар / оны хичээлийн жилийн улирлаас/..... оны хичээлийн
жилийн улирал хүртэл улирлын чөлөө авсан бөгөөд энэ улирлаас эхлэн
үргэлжлүүлэн суралцах хүсэлтэй тул зөвшөөрөл олгоно уу?

Жич. Суралцах улирлын сургалтын төлбөр төлсөн баримтыг хавсаргав.

Оюутан

Харилцах утасны дугаар:

Хавсралт 5. Шилжин суралцах тухай өргөдлийн загвар

ХААИС-ийн сургуулийн сургалтын албанд

Өргөдөл гаргах нь

20.... оны ... сарын ...-ний өдөр

Миний бие овогтой нь тус сургуулийн
..... хөтөлбөрөөр кодтой суралцдаг.

.....
..... шалтгаанаар танай сургуулийн хөтөлбөрийн-р курст үргэлжлүүлэн
суралцах хүсэлтэй тул зөвшөөрөл олгоно уу?

Жич. Холбогдох материалуудыг хавсаргав.

Оюутан

Харилцах утасны дугаар:

Хавсралт 6. Шилжин явах, сургуулиас гарах тухай өргөдлийн загвар

ХААИС-ийн сургуулийн сургалтын албанд

Өргөдөл гаргах нь

20.... оны ... сарын ...-ний өдөр

Миний бие овогтой нь тус сургуулийн
..... хөтөлбөрөөр кодтой суралцдаг.

.....
.....
.. шалтгаанаар сургуульд шилжин суралцах/сургуулиас
гарах (*аль тохирохыг сонгох*) хүсэлтэй тул холбогдох бичиг баримтуудыг буцаан
олгож өгч тусална уу?

Оюутан

Харилцах утасны дугаар:

Хавсралт 7. Анхааруулах хуудасны загвар

Анхааруулах хуудас

№: ...

..... хөтөлбөрөөр суралцаж буй оюутан
..... овогтой таныг/..... оны
хичээлийн жилийн . . . улиралд **0.7**-оос доош голч бүхий үнэлгээтэй
суралцсан тул анхааруулах хуудсаар сануулж байна. Та дахин ... удаа
анхааруулах хуудас авбал “ХААИС-ийн сургалтын журмын” 5.4.1-ийн 9-р
зүйлд заасны дагуу сургуулиас чөлөөлөх болохыг анхааруулж байна.

Сургалтын бодлого, зохицуулалтын алба

..... оны сарын -ний өдөр

Хавсралт 8. Захирлын нэрэмжит батламжийн загвар

ХААИС-ийн захирлын нэрэмжит батламж

№: ...

..... хөтөлбөрөөр суралцаж буй оюутан
овогтой таныг/..... оны хичээлийн жилийн . . .
улиралд үнэлгээний голч дүнтэй суралцаж, сурлагын өндөр амжилт гаргасан тул
талархал илэрхийлж “Захирлын нэрэмжит батламж” олгов. Та дахин ... удаа
“Захирлын нэрэмжит батламж” авбал Таныг “Шилдэг оюутан”-аар өргөмжилж
сургалтын төлбөрийн 20 хувиар хөнгөлөлт үзүүлэн урамшуулах болно.

Захирал:

..... оны сарын -ний өдөр